



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

“ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ”



ОРА-2017/НА-05



Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа хууль журмын зохих шаардлагыг бүрэн гаргаж төлөвлөөгүй боловч бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль, журмын дагуу тайлагнан, хяналт, шинжилгээ үнэлгээг хийж олон нийтэд мэдээлэх, сурталчилах ажлыг орон нутгийн захиргааны байгууллагууд зохион байгуулсан байна.

Орхон аймаг
2017 он

Аудитын тайланг бэлтгэсэн:	Агуулга 1 Товчилсон үгсийн жагсаалт 2 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 3-4
Орхон дахь Төрийн аудитын газар	Бүлэг I. Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа тухайн салбарын орчны шинжилгээг орхигдуулсан, эдийн засаг, нийгэм болон салбарын динамик үзүүлэлтийг тайлбарлаагүй, санал болгож байгаа үйл ажиллагааны цаад үндэслэлийг гаргаагүй, улмаар санал бодитой, үндэслэлтэй эсэхийг оролцогчид мэдэх техник, эдийн засгийн шинжилгээ байхгүй байна.
Дарга, тэргүүлэх аудитор :	Ц.Нармандах 1.1 Орхон аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх Үйл ажиллагааны болон түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, иргэний нийгмийн байгууллагууд, эрдэмтэд, төрийн болон аж ахуйн нэгж байгууллагууд, иргэдийн саналд үндэслэн боловсруулан, аймгийн ИТХ-р батлуулсан байна.....5-7
Аудитын менежер:	Б.Эрдэнэ 1.2 Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа хууль, журмын дагуу нөхцөл байдлын дүн шинжилгээ хийн, зорилго зорилтын уялдааг тодорхойлж бодлогын хувилбаруудыг боловсруулах ажил хууль журмын дагуу хийгдээгүй байна.....7-9 1.3 Хөгжлийн бодлогын баримт бичгийн хувилбаруудад нөлөөллийн урьдчилсан үнэлгээг журамд заасны дагуу хийгээгүй боловч төслийг олон нийтээр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулсан байна.10-11
Аудитор	О.Дашжамц Д.Цогбадрах 1.4 Хөгжлийн бодлогын баримт бичигт зорилго, зорилтыг тодорхойлсон боловч, зарим хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, санхүүгийн тооцооллыг тусгаагүй байна.12-13 1.5 Аймаг, сумын Засаг дарга нар дэд хөтөлбөрийн жагсаалтыг боловсруулж ИТХ-р батлуулаагүй байна.13 1.6 Хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий байгууллага хууль журамд заасан үүргээ хэрэгжүүлсэн байна.13-14
2017 оны 12 дугаар сар	Бүлэг II. Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль, журмын дагуу тайлагнан, хяналт-шинжилгээ, үнэлгээг хийжээ. 2.1 Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль, журамд заасан хугацаанд тайлагнасан байна.14-15 2.2 Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хууль, журмын дагуу хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, хуулиар тодорхойлсон хугацаанд холбогдох байгууллагад танилцуулсан байна.15-16 2.3. Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг нэгтгэх, үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих, үүрэг бүхий байгууллага болон албан тушаалтан үүргээ бүрэн хэрэгжүүлэн тайлагнасан байна. 16-18
Аудитын тайланг холбоотой асуудлаар нэмж, тодруулах, лавлах зүйл байвал 70357955, 70350757 дугаарын утас, 70359826 дугаарын факсаар харилцана уу.	Бүлэг III. Олон нийтэд мэдээлэх, сурталчилах ажлыг орон нутгийн захиргааны байгууллагууд зохион байгуулсан байна. 3.1 Хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, сурталчилах ажлыг зохион байгуулсан байна.19 3.2. Орон нутгийн ИТХ, Засаг дарга, түүний харъяа агентлаг, байгууллага, ЗДТГ нь бодлогын бичиг баримтуудыг олон нийтэд мэдээлэх сурталчилах үүргээ хэрэгжүүлэн ажиллажээ. 19
Аудитын тайланг УАГ-ын веб сайтаас үзнэ үү. www.audit.mn	Дүгнэлт20 Зөвлөмж20 Мэдэгдэл20
Хаяг: Орхон аймаг дахь төрийн аудитын газар	
Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Нутгийн удирдлагын ордон	

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний Аудитын газар
ОА	Орхон аймаг
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
БСУГ	Боловсрол соёл урлагын газар
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ОНХ	Олон нийттэй харилцах
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ААН	Аж ахуйн нэгж
ТББ	Төрийн бус байгууллага
НАГ	Нийцлийн аудитын газар
НА	Нийцлийн аудит

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл:

Аудит хийх үндэслэл: Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2017 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Үндэсний аудитын газрын 2017 онд хийх аудитын төлөвлөгөө”-ний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт: Хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ үнэлгээ хийх үе шат, баримтлах зарчим, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлсэн эсэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудит хийнэ. Үүнд:

- Хөгжлийн бодлогын баримт бичгийг хууль, тогтоомж, журамд нийцүүлэн төлөвлөж, боловсруулан баталсан эсэх;
- Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль, журмын дагуу тайлагнаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн эсэх;
- Хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, арга зүйн нэгдсэн удирдамжаар хангах ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулж байгаа эсэх.

Аудитын хамрах хүрээ: Аудитад Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн дагаж мөрдөж эхэлсэн 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш боловсруулан баталж, хэрэгжиж байгаа хөгжлийн бодлогын баримт бичгийн хүрээнд аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, түүний харъяа агентлаг, байгууллага, Засаг даргын тамгын газрыг хамарууллаа.

Аудитын арга зүй: Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 4100 дугаар стандартууд, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан шалгагдагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, түүвэрлэлт хийх болон аудитын бусад горим, арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу газар дээр нь очиж биет болон баримтат нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт: Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглана. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль;
- Засгийн газрын тухай хууль;
- Хууль тогтоомжийн тухай хууль;
- Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль;
- Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”;
- Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”;
- Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Засгийн газрын 2016-2020 онд шинээр боловсруулах болон үргэлжлүүлэн хэрэгжүүлэх “Үндэсний хөтөлбөр”-ийн жагсаалт;
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам.
- Орхон аймгийн Засаг даргын 2012-2016, 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр

Гүйцэтгэсэн хугацаа: Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2017 оны 10 сарын 25-аас эхлүүлэн, талбарын ажлыг 11 сарын 01-ээс эхлүүлж аудитын тайланг 12 дугаар сарын 06-аас эхэлж, тайлангийн төслийг 12 дугаар сарын 19-нд газрын удирдлагад танилцуулан, 12 дугаар сарын 20-нд Үндэсний аудитын газарт баталгаажуулан хүргүүллээ.

Үндсэн мэдээлэл: Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, баримтлах зарчим, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхэд Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн зорилт чиглэсэн байна.

Энэхүү хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь заалтад зааснаар “Хөгжлийн бодлогын баримт бичиг”-ийг “Үндэсний, салбарын, салбар хоорондын болон бүс нутаг, аймаг, нийслэлийн түвшинд, урт, дунд, богино хугацааны зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга зам, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тусгасан, эрх бүхий этгээдээс баталсан, энэ хуулийн 4.1.1-4.1.11-д заасан баримт бичиг” гэж тодорхойлж өгсөн байна.

**Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хүрээнд аймаг, сумдын ИТХ-аас
баталсан хөтөлбөрүүдийн жагсаалт**

№	Баримт бичгийн төрөл	Батлагдсан огноо	Шийдвэрийн дугаар	Тоо
Хуулийн 14 дүгээр зүйлд заасан:				
1	Аймгийг хөгжүүлэх хэтийн зорилт	-	-	-
2	Баян-Өндөр сумын түвшинд эдийн засаг нийгмийг хөгжүүлэх орон нутгийн онцлогыг тусгасан хөгжлийн дунд хугацааны бодлого	9/9/2016	03	1
3	Жаргалант сумын түвшинд эдийн засаг нийгмийг хөгжүүлэх орон нутгийн онцлогыг тусгасан хөгжлийн дунд хугацааны бодлого	12/14/2016	02	1
Хуулийн 15 дугаар зүйлд заасан:				
Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон дэд хөтөлбөр				
4	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр	10/28/2016	01	1
5	"Багш" дэд хөтөлбөр	3/31/2017	6/02	1
6	"Эмч" дэд хөтөлбөр	3/31/2017	6/04	1
7	Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай буюу ажлын байр дэд хөтөлбөр	2/17/2017	05/02	1
8	Багийн хөгжлийн дэд хөтөлбөр	4/28/2017	56	1
9	Чөлөөт цагийн талбай дэд хөтөлбөр	5/15/2017	64	1
10	Ахмад настны "Ач санах" дэд хөтөлбөр	5/15/2017	65	1
11	Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр	5/15/2017	63	1
12	Өрхийн тариалалтыг дэмжих дэд хөтөлбөр	4/28/2017	52	1
13	Аймгийн боловсролын салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх дэд хөтөлбөр	3/31/2017	6/01	1
14	Баян-Өндөр сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр	11/24/2016	02	1
Жаргалант сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон дэд хөтөлбөр				
15	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр	12/14/2016	01	1
16	"Малжуулах" хөтөлбөр	12/14/2016	03	1
17	"Боловсрол" дэд хөтөлбөр		02	1
18	"Хог хаягдлын менежментийг сайжруулах" хөтөлбөр	2/3/2017	03	1

19	"Малын хулгайтай тэмцэх" богино хугацааны хөтөлбөр		04	1
Хуулийн 16 дугаар зүйлд заасан:				
20	Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл	12/2/2016	02	1
21	Баян-Өндөр сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл	12/11/2015	03	1
22		12/20/2016	02	1
23	Жаргалант сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл	12/14/2016	04	1
Нийт				22

**Орхон аймаг дахь
Төрийн аудитын
газар**

Хөгжлийн бодлогын баримт бичгийг хууль, тогтоомжид нийцүүлэн төлөвлөж, боловсруулан баталсан уу.

Бүлэг 1

Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа тухайн салбарын орчны шинжилгээг орхигдуулсан, эдийн засаг, нийгэм болон салбарын динамик үзүүлэлтийг тайлбарлаагүй, санал болгож байгаа үйл ажиллагааны цаад үндэслэлийг гаргаагүй, улмаар санал бодитой, үндэслэлтэй эсэхийг оролцогчид мэдэх техник, эдийн засгийн шинжилгээ байхгүй байна.

1.1 Орхон аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх Үйл ажиллагааны болон түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, иргэний нийгмийн байгууллагууд, эрдэмтэд, төрийн болон аж ахуйн нэгж байгууллагууд, иргэдийн саналд үндэслэн боловсруулан, аймгийн ИТХ-р батлуулсан байна.

Орхон аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх Үйл ажиллагааны болон түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, иргэний нийгмийн байгууллагууд, эрдэмтэд, төрийн болон аж ахуйн нэгж байгууллагууд, иргэдийн саналд үндэслэн боловсруулан аймгийн ИТХ-р батлуулсан нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15.2-д "Засаг дарга аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг, түүнийг хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийн жагсаалтын хамт боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна" гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

МУ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь "Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг төсөв санхүүгийн эх үүсвэртэй уялдуулан дэд хөтөлбөрт тусган хэрэгжүүлнэ" гэсэн заалтын дагуу аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан 24 дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 14-н хөтөлбөрийг боловсруулан аймгийн ИТХ-р батлуулж, 6-н хөтөлбөр боловсруулалтын шатанд, 4-н хөтөлбөрийг боловсруулаагүй байна.

Эмч, Багш, Жаргалант сумын боловсрол дэд хөтөлбөрөөс бусад 14 хөтөлбөр нь хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах төлөвлөгөө боловсруулаагүй байна.

Аймгийн Засаг дарга бөгөөд Эрдэнэт хотын Захирагчийн 2016-2020 оны Үйл ажиллагааны хөтөлбөр болон хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд:

Нэгдүгээрт: ЭРҮҮЛ –АЗ ЖАРГАЛТАЙ ИРГЭД

Хоёрдугаарт: НИЙГМИЙН ДЭМЖЛЭГТЭЙ –АЗ ЖАРГАЛТАЙ ИРГЭД

Гуравдугаарт: АЖИЛТАЙ-АЗ ЖАРГАЛТАЙ ИРГЭД

Дөрөвдүгээрт: ОЮУНЛАГ, ЁС ЗҮЙ, СОЁЛТОЙ-АЗ ЖАРГАЛТАЙ ИРГЭД

Тавдугаарт: ЭРҮҮЛ ХҮНС, ЦЭВЭР ОРЧИНТОЙ - АЗ ЖАРГАЛТАЙ ИРГЭД

Зургаадугаарт: САЙХАН ХОТЫН-АЗ ЖАРГАЛТАЙ ИРГЭД

Долоодугаарт: АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ӨГӨӨЖТЭЙ-АЗ ЖАРГАЛТАЙ ИРГЭД

Наймдугаарт: ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТТЭЙ-АЗ ЖАРГАЛТАЙ ИРГЭД

Есдүгээрт: ЧАДВАРЛАГ ЗАСАГЛАЛТАЙ -АЗ ЖАРГАЛТАЙ ИРГЭД

гэсэн үндсэн 9 бүлэг 116 зорилт, 298 багц арга хэмжээг хэрэгжүүлэхээр хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-5.1.7 дахь заалтыг үндэслэн хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулан аймгийн ИТХ-ын 2016 оны 10-р сарын 28-ны өдрийн 01 тоот тогтоолоор батлуулсан байна.

Засаг дарга нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15.2-т заасны дагуу аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлуулсан боловч хөтөлбөрт тусгагдсан 24-н дэд хөтөлбөрийн жагсаалтыг батлуулаагүй нь хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15.2-т заасан “Засаг дарга аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг, түүнийг хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийн жагсаалтын хамт боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна” гэсэн заалт, нийтлэг журмын 44, 45, 46-р заалтуудтай нийцээгүй байна.

Доорхи 11 дэд хөтөлбөрийг аймгийн ИТХ-аар батлуулсан байна.

№	Баримт бичгийн төрөл	Батлагдсан огноо	Шийдвэрийн дугаар	Тоо
1	Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр	3/31/2017	6/04	1
2	"Багш" дэд хөтөлбөр	3/31/2017	6/02	1
3	"Эмч" дэд хөтөлбөр	3/31/2017	6/04	1
4	Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай буюу ажлын байр дэд хөтөлбөр	2/17/2017	05/02	1
5	Багийн хөгжлийн дэд хөтөлбөр	4/28/2017	56	1
6	Чөлөөт цагийн талбай дэд хөтөлбөр	5/15/2017	64	1
7	Ахмад настны "Ач санах" дэд хөтөлбөр	5/15/2017	65	1
8	Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр	5/15/2017	63	1
9	Өрхийн тариалалтыг дэмжих дэд хөтөлбөр	4/28/2017	52	1
10	Аймгийн боловсролын салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх дэд хөтөлбөр	3/31/2017	6/01	1
11	"Аялал жуулчлалыг хөгжүүлэх" аймгийн дэд хөтөлбөр	27/10/2017	08/03	1

“Ач санах”, “Эрдэнэтчүүд, Эрдэнэтчүүддээ хайртай”, “Чөлөөт цагийн талбай”, “Багийн хөгжлийг дэмжих”, аймгийн боловсролын салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх дэд хөтөлбөрүүдэд төсөл боловсруулах ажлын хэсэг нь нийтлэг журмын 17, 18-д заасан байдлаар төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй байна.

“Эмч” дэд хөтөлбөр, “Багш”, Жаргалант сумын “боловсрол” дэд хөтөлбөрүүдэд төсөл боловсруулах ажлын хэсэг нь тодорхой төлөвлөгөөтэй ажилласан байна.

Мөн “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх”, “Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай буюу ажлын байр”, “Багийн хөгжлийг дэмжих”, “Төрөөс хүнс, хөдөө

аж ахуйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх", "Өрхийн тариалалтыг дэмжих", "Аялал жуулчлалыг хөгжүүлэх" "Аймгийн боловсролын салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх" дэд хөтөлбөрүүд болон Жаргалант сумын "Хог хаягдлын менежментийг сайжруулах" дэд хөтөлбөр, "Малын хулгайтай тэмцэх" богино хугацааны хөтөлбөрүүдийг боловсруулахдаа төсөл боловсруулах ажлын хэсэг нь нийтлэг журмын 17, 18-д заасан байдлаар төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй байна.

Жаргалант сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон дэд хөтөлбөр:

№	Баримт бичгийн төрөл	Батлагдсан огноо	Шийдвэрийн дугаар	Тоо
1	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр	12/14/2016	01	1
2	"Боловсрол" дэд хөтөлбөр	2016.12.14	02	1
3	"Хог хаягдлын менежментийг сайжруулах" хөтөлбөр	2/3/2017	03	1
4	"Малын хулгайтай тэмцэх" богино хугацааны хөтөлбөр		04	1

Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах ажилд Засаг дарга нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 89 дугаар тогтоолоор баталсан "Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам"-д дараах үүрэг хүлээхээр заасан байна.

- Засаг дарга нь дараах төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Тамгын газар, Засаг даргын дэргэдэх агентлаг, төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, эрдэмтэн, судлаач, мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулан байгуулж, удирдамжаар ханган, үйл ажиллагаанд нь хяналт тавина¹:
 - 13.1.аймаг нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт
 - 13.2.дэд хөтөлбөр
- Энэ журмын 12, 13-т заасан Ажлын хэсэг нь төсөл боловсруулах төлөвлөгөөтэй байна.²

Төслийн ажлын хэсгүүдийг Засаг даргын захирамж болон ИХТ-аар баталсан боловч нийтлэг журмын 17,18-д заасны дагуу төлөвлөгөө гаргаж ажиллаагүй байна.

1.2. Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа хууль, журмын дагуу нөхцөл байдлын дүн шинжилгээ хийн, зорилго зорилтын уялдааг тодорхойлж бодлогын хувилбаруудыг боловсруулах ажил хууль журмын дагуу хийгдээгүй байна.

Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах ажлыг захиргааны байгууллага Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, журмын дагуу дараах байдлаар хийхээр тусгасан байна.Үүнд:

- Төсөл боловсруулах үйл ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөөнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа болон хариуцан гүйцэтгэх, оролцох талын нэрийн хамт тусгана³:
- Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх⁴

¹ Засгийн газрын 2016 оны 05-р сарын 09-ний өдрийн 249 дугаар "Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам"-ын "Төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах" гэсэн 2 дугаар зүйлийн 13 дахь заалт

² Журмын 3 дугаар зүйлийн 17 дахь заалт

³ Журмын 3 дугаар зүйлийн 18 дахь заалт

⁴ Журмын 3 дугаар зүйлийн 18.1 дэх заалт

- Аймгийн Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийхдээ тухайн бодлогын баримт бичигт тусган шийдвэрлэх эдийн засаг, нийгэм, эсхүл тодорхой зорилтот бүлэгт эрт дунд хугацаанд тулгамдаж байгаа зайлшгүй шийдвэрлэх хүндрэл, бэрхшээлийг мэдэрч, асуудлыг судалж тодорхойлно. Энэхүү судалгаанд өмнө нь уг асуудлаар хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжлтийн хяналт, шинжилгээ үнэлгээний тайлан, статистик судалгаа, түүвэр судалгаа, олон нийтийн зүгээс давтагдан гарч байгаа санал, шүүмжлэл зэргийг ашиглана.⁵
- Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх ажилд тухайн асуудлаас хамааруулан холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, мэргэжлийн холбоод, холбогдох бусад талуудыг оролцуулна.⁶
- Төслийн нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх болон төслийг боловсруулах явцад тухайн асуудалтай холбоотой мэдээллээс иш татсан тохиолдолд бодлогын баримт бичиг болон судалгаа, мэдээллийн эх сурвалжийг заана.⁷
- Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх ажилд тухайн асуудлаас хамааруулан холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, мэргэжлийн холбоод, холбогдох бусад талуудыг оролцуулна.⁸
- Төслийн нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх болон төслийг боловсруулах явцад тухайн асуудалтай холбоотой мэдээллээс иш татсан тохиолдолд бодлогын баримт бичиг болон судалгаа, мэдээллийн эх сурвалжийг заана.⁹

Аймгийн ИТХ-р баталсан дэд хөтөлбөрийн хувьд:

"Ач санах" дэд хөтөлбөрийг боловсруулахдаа холбогдох Төрийн болон Төрийн бус байгууллага болох аймгийн Ахмадын хороо, УБЭҮ-ийн Ахмадын нэгдсэн зөвлөл, "Буурлын чагнуур" ТББ, "МАЗН"-ын анхдагч илгээлтийн эздийн эрх ашгийг хамгаалах "Баатар" холбоо, Ахмад багш нарын "Соёмбо" холбоо, "Эрдэнэтийн овооны анхдагч илгээлтийн эздийн холбоо" ТББ болон холбогдох төрийн байгууллагуудыг оролцуулсан байна.

"Багш" дэд хөтөлбөрийг боловсруулахдаа ашигласан хяналт үнэлгээний тайлан гэж байхгүй, харин статистик судалгаа, түүвэр судалгаа, боловсролын байгууллагуудын санал шүүмжлэл зэргийг ашиглаж боловсруулжээ.

"Эмч" дэд хөтөлбөрийг боловсруулахдаа ажлын хэсэг нь статистик судалгаа, түүвэр судалгаа, олон нийтийн зүгээс давтагдан гарч байгаа санал шүүмжлэл зэргийг ашигласан байна.

"Эрдэнэтчүүд Эрдэнэтчүүддээ хайртай" дэд хөтөлбөрийг боловсруулахдаа холбогдох төрийн байгууллагуудын төлөөллийг сайн оролцуулсан боловч төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулаагүй, тухайн асуудалтай холбоотой мэдээллийг бусад хүчин төгөлдөр бодлогын баримт бичиг судалгаа мэдээллээс иш татсан тохиолдолд бодлогын баримт бичиг болон судалгаа мэдээллийн эх сурвалжийг заасан зүйл байхгүй боловч эрх зүйн жагсаалтыг гаргаж хавсаргасан байна.

"Чөлөөт цагийн талбай" дэд хөтөлбөрийг боловсруулахдаа холбогдох төрийн байгууллагуудын төлөөллийг сайн оролцуулсан боловч Төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, мэргэжлийн холбоод, ажил олгогч ААН-үүдийн төлөөллийг оролцуулаагүй, бодлогын хэрэгжилтийн хяналт, шинжилгээ үнэлгээний тайланг

⁵ Журмын 4 дүгээр зүйлийн 20 дахь заалт

⁶ Журмын 4 дүгээр зүйлийн 21 дэх заалт

⁷ Журмын 4 дүгээр зүйлийн 22 дахь заалт

⁸ Журмын 4 дүгээр зүйлийн 21 дэх заалт

⁹ Журмын 4 дүгээр зүйлийн 22 дахь заалт

ашиглаагүй боловч статистик судалгаа, өмнө нь хийгдсэн ажлын судалгаа, ЕБС-уудын болон олон нийтийн санаа бодлыг тусган ажиллажээ.

"Багийн хөгжлийг дэмжих" дэд хөтөлбөрийг боловсруулахдаа бодлогын хэрэгжилтийн хяналт, шинжилгээ үнэлгээний тайланг ашиглаагүй боловч статистик судалгаа, хувиараа хөдөлмөр эрхлэгчид ажиллагсад болон олон нийтийн санаа бодлыг тусгаж ажилласан ба төрийн байгууллагуудын төлөөллийг сайн оролцуулсан боловч Төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулаагүй байна.

"Өрхийн тариалалтыг дэмжих" дэд хөтөлбөрийг боловсруулахдаа бодлогын хэрэгжилтийн хяналт, шинжилгээ үнэлгээний тайланг ашиглаагүй боловч статистик судалгаа, хувиараа хөдөлмөр эрхлэгчид ажиллагсад болон олон нийтийн санаа бодлыг тусгаж ажилласан ба хөтөлбөр боловсруулахад холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөллийг оролцуулсан боловч эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын төлөөллийг оролцуулаагүй байна.

"Төрөөс хүнс, ХАА-н талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх" дэд хөтөлбөрийг боловсруулахдаа бодлогын хэрэгжилтийн хяналт, шинжилгээ үнэлгээний тайланг ашиглаагүй боловч статистик судалгаа, өмнө хийгдсэн ажлын судалгаа, малчид болон олон нийтийн санаа бодлыг тусгаж ажилласан байна.

Аймгийн боловсролын салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх дэд хөтөлбөрийг боловсруулахдаа хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 19.2-т заасны дагуу хэлэлцүүлэг зохион байгуулсан, хэлэлцүүлэгт их, дээд сургуулиуд, ТББ-ууд, төрийн байгууллагууд, МСҮТ-үүд болон бусад байгууллагууд оролцсон ба "Эрдэнэтийн гүүшүүд" ТББ, Эрдэнэтийн анхдагчдын "Соёмбо" ТББ, Насан туршийн боловсролын төв, МУИС-ийн Орхон их сургууль, Орхон МСҮТ, ХАА-н МСҮТ, "Маргад" дээд сургууль, Эрдэнэт үйлдвэрийн харъяа Технологийн сургууль, ИТХ-ын даргын БСУГ-ын төлөөлөлтэй хийсэн уулзалт, ярилцлагаас гарсан санал, ИТХ-ын нийгмийн бодлогын хорооны санал зэргийг тусгаж ажилласан байна.

"Эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх" дэд хөтөлбөрийг боловсруулахдаа хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 19.2-т заасны дагуу хэлэлцүүлэг зохион байгуулсан, хэлэлцүүлэгт ЭМГ, БОЭТ, ӨЭМТ-үүд, сумын ЭМТ, ХХЭМБ, Медипас эмнэлэг, Эм холбоо, Эрдэнэт сувилалын цогцолбор, Залуу эмч нарын холбоо, иргэдийн фокус бүлэг зэрэг оролцсон ба нөлөөллийн урьдчилсан үнэлгээг гүйцэтгэж, төсөлд тусгасан байна.

Сумын ИТХ-р баталсан дэд хөтөлбөрийн хувьд:

Жаргалант сумын "Боловсрол", "Малын хулгайтай тэмцэх" богино хугацааны хөтөлбөр, "Хог хаягдлын менежментийг сайжруулах" дэд хөтөлбөрүүдэд нөхцөл байдлын дүн шинжилгээг хангалтгүй хийсэн байна.

Нөхцөл байдлын дүн шинжилгээг хийж, бодлогын зорилго, зорилтын уялдааг боловсруулан хувилбаруудыг боловсруулсан гэх боловч нотлох баримт байхгүй байна.

1.3. Хөгжлийн бодлогын баримт бичгийн хувилбаруудад нөлөөллийн урьдчилсан үнэлгээг журамд заасны дагуу хийгээгүй боловч төслийг олон нийтээр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулсан байна.

Хөгжлийн бодлогын баримт бичгийн хувилбаруудад нөлөөллийн урьдчилсан үнэлгээг дараах байдлаар хийхээр хууль, журамд тусгасан байна.Үүнд:

- Нөлөөллийн урьдчилсан үнэлгээг төсөл санаачлан боловсруулж байгаа захиргааны байгууллага хариуцан гүйцэтгэж, уг үнэлгээний дүгнэлтийг төсөлд тусгасан байна.¹⁰
- Эдийн засаг нийгэм, эсхүл тодорхой зорилтот бүлэгт урт дунд хугацаанд тулгамдаж байгаа зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай ажил үйлчилгээтэй холбоотой асуудлын эдийн засаг, нийгэм, байгаль орчин болон санхүүгийн салбарт үзүүлэх эерэг болон сөрөг нөлөө нь их гэж үзсэн тохиолдолд нөлөөллийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.¹¹
- Нөлөөллийн урьдчилсан үнэлгээг өмнө хийсэн судалгаа үнэлгээ, албан ёсны тоон болон чанарын мэдээлэлд үндэслэн хийнэ.¹²

Хөгжлийн бодлогын баримт бичгийн хувилбаруудад нөлөөллийн урьдчилсан үнэлгээг аймгийн ИТХ-р баталсан зарим дэд хөтөлбөрүүд болон сумдын зарим хөтөлбөрүүдэд дутуу хийгдсэн байна.

Тухайлбал: **Аймгийн ИТХ-р баталсан дэд хөтөлбөрийн хувьд:**

"Ач санах" дэд хөтөлбөр, нөлөөллийн урьдчилсан үнэлгээг гүйцэтгэж, төсөлд тусгаагүй, эдийн засаг нийгэм эсвэл тодорхой зорилтот бүлэгт урт дунд хугацаанд тулгамдаж байгаа зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай ажил үйлчилгээтэй холбоотой асуудлын эдийн засаг, нийгэм, байгаль орчин болон санхүүгийн салбарт үзүүлэх эерэг болон сөрөг нөлөө их гэж үзсэн судалгаа байхгүй.

Шинэчлэн батлагдсан ахмад настны тухай хуулийг сурталчилах, дэд хөтөлбөрт санал авах зорилгоор ахмадын хороотой хамтран 21 багийн 500 гаруй ахмадуудтай уулзалт хийж, хэлэлцүүлэг өрнүүлсэн ба хэлэлцүүлэг болохоос 5-с доошгүй өдрийн өмнө төслийг бичгээр болон цахим хэлбэрээр хэлэлцүүлэгт оролцогчдод хүргүүлсэн эсэх нь тодорхойгүй, баримтанд байхгүй байна.

"Багш" дэд хөтөлбөр төсөл санаачлан боловсруулж байгаа захиргааны байгууллага нөлөөллийн урьдчилсан үнэлгээг тооцож гаргасан ба эдийн засаг нийгэм эсвэл тодорхой зорилтот бүлэгт урт, дунд хугацаанд тулгамдаж байгаа зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай ажил үйлчилгээтэй холбоотой асуудлын эдийн засаг, нийгэм, байгаль орчин болон санхүүгийн салбарт үзүүлэх эерэг болон сөрөг нөлөө их гэж үзээгүй тул төслийг өөрсдөө боловсруулсан байна.

Хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг нь СӨББ, ЕБС, Их, Дээд сургууль, МСҮТ, Ахмад багш, Эрдэмтэдийн төлөөлөл бүхий 715 хүнтэй хэлэлцүүлэг хийсэн нь нийт багш, удирдах ажилтны 41 хувь болсон ба төслийн талаар хувь хүн, хуулийн этгээд, төрийн байгууллага, холбогдох байгууллага, мэргэжлийн холбоодоос бичгээр болон цахимаар санал авч ажиллажээ.

"Эмч" дэд хөтөлбөрт эдийн засаг нийгэм эсвэл тодорхой зорилтот бүлэгт урт дунд хугацаанд тулгамдаж байгаа зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай ажил үйлчилгээтэй холбоотой асуудлын эдийн засаг, нийгэм, байгаль орчин болон санхүүгийн салбарт үзүүлэх эерэг болон сөрөг нөлөө их гэж үзсэн судалгаа байхгүй байна.

Харин Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 19.2-т заасны дагуу эмч, эмнэлгийн ажиллагсадын санал бодлыг тусгах зорилгоор ажлын хэсгийн болон эрүүл мэндийн байгууллагуудын "Залуу эмч нарын холбоо" ТББ, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч ажиллагсад, БОЭТ-ийн эмч ажиллагсадын уулзалтуудыг зохион байгуулан, нийт 239 гаруй хүмүүс, өрхийн анагаах ухааны мэргэжилтний холбоо, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын "Чандмань-Эрдэнэ" Холбоо, Эрүүл мэндийн байгууллагуудын "Залуу эмч нарын холбоо" ТББ, ахмад эмч, ажиллагсадын "Бүүрлын чагнуур" НҮТББ, ИТХ-ын тэргүүлэгчид, төлөөлөгчдийн саналыг авч тусгасан байна.

¹⁰ Журмын 5 дугаар зүйлийн 24 дэх заалт

¹¹ Журмын 5 дугаар зүйлийн 25 дахь заалт

¹² Журмын 5 дугаар зүйлийн 26 дахь заалт

"Эрдэнэтчүүд Эрдэнэтчүүддээ хайртай" дэд хөтөлбөрийг боловсруулахдаа хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 19.2-т заасны дагуу хэлэлцүүлэг зохион байгуулахад 288 иргэн оролцож, 21 иргэн саналаа хэлж, 58 иргэн бичгээр санал өгчээ.

Эдийн засаг нийгэм эсвэл тодорхой зорилтот бүлэгт урт дунд хугацаанд тулгамдаж байгаа зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай ажил үйлчилгээтэй холбоотой асуудлын эдийн засаг, нийгэм, байгаль орчин болон санхүүгийн салбарт үзүүлэх эерэг болон сөрөг нөлөө их гэж үзсэн судалгаа, нөлөөллийн урьдчилсан үнэлгээг гүйцэтгэж, төсөлд тусгаагүй байна.

"Чөлөөт цагийн талбай" дэд хөтөлбөрийг боловсруулахдаа нөлөөллийн урьдчилсан үнэлгээг журамд заасны дагуу гүйцэтгэж, хөтөлбөрт тусгаагүй, хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 19.2-т заасны дагуу хэлэлцүүлэг зохион байгуулахад 21 багийн 5930 иргэн, 50 гаруй багш, ажилтан, 294 өрх айл оролцсон байна.

"Багийн хөгжлийг дэмжих" дэд хөтөлбөрийг боловсруулахдаа нөлөөллийн урьдчилсан үнэлгээг журамд заасны дагуу гүйцэтгэж, хөтөлбөрт тусгасан, хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 19.2-т заасны дагуу хэлэлцүүлэг зохион байгуулж 2500 гаруй иргэдэд мэдээлэл, суртчилгаа хүргэж, ажилласан байна.

"Өрхийн тариалалтыг дэмжих" дэд хөтөлбөрийг боловсруулахдаа нөлөөллийн урьдчилсан үнэлгээг журамд заасны дагуу гүйцэтгэж, хөтөлбөрт тусгасан, хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 19.2-т заасны дагуу хэлэлцүүлэг зохион байгуулж хэлэлцүүлэгт Дулаан-Уул, Жаргалант багын иргэдийг идэвхтэй оролцуулж, зарим иргэдээс бичгээр санал авсан ба иргэдээс цахимаар санал аваагүй байна.

"Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх" аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулахдаа Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 19.2-т заасны дагуу Дулаан-Уул, Жаргалант багийн иргэд оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулж 21 багийн 385-н иргэдийг хамруулж, хувь хүн, хуулийн этгээд, төрийн байгууллага, холбогдох байгууллага, мэргэжлийн холбоодоос бичгээр болон цахимаар санал авсан байна.

Аймгийн боловсролын салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх дэд хөтөлбөрийг боловсруулахдаа нөлөөллийн урьдчилсан үнэлгээг гүйцэтгэж, төсөлд тусгаагүй, "Эрдэнэтийн гүүшүүд" ТББ, Эрдэнэтийн анхдагчдын "Соёмбо" ТББ, Насан туршийн боловсролын төв, МУИС-ийн Орхон их сургууль, Орхон МСҮТ, ХАА-н МСҮТ, "Маргад" дээд сургууль, "Эрдэнэт" үйлдвэрийн харъяа Технологийн сургууль, ИТХ-ын даргын БСУГ-ын төлөөлөлтэй хийсэн уулзалт, ярилцлагаас гарсан санал, ИТХ-ын Нийгмийн бодлогын хорооны санал зэргийг тусгаж ажилласан байна.

"Эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх" дэд хөтөлбөрийг боловсруулахдаа нөлөөллийн урьдчилсан үнэлгээг журамд заасны дагуу гүйцэтгэж, төсөлд тусгасан ба хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 19.2-т заасны дагуу хэлэлцүүлэг зохион байгуулаж ЭМГ, БОЭТ, ӨЭМТ-үүд, сумын ЭМТ, ХХЭМБ, Медипас эмнэлэг, Эм холбоо, Эрдэнэт сувилалын цогцолбор, Залуу эмч нарын холбоо, иргэдийн фокус бүлэг зэрэг байгууллагуудыг хамруулсан байна.

Сумын ИТХ-р батласан дэд хөтөлбөрүүдийн хувьд олон нийтээр хэрхэн хэлэлцүүлсэн нь дараах байдалтай байна.Үүнд:

- Жаргалант сумын "Боловсрол", "Малын хулгайтай тэмцэх" богино хугацааны хөтөлбөр, "Хог хаягдлын менежментийг сайжруулах" дэд хөтөлбөрүүд нөлөөллийн урьдчилсан үнэлгээг журамд заасны дагуу гүйцэтгээгүй, төслийн саналыг олон нийтээр хэлэлцүүлэх ажлыг огт зохион байгуулаагүй байна.

1.4. Хөгжлийн бодлогын баримт бичигт зорилго, зорилтыг тодорхойлсон боловч, зарим хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, санхүүгийн тооцооллыг тусгаагүй байна.

А.Хөгжлийн бодлогын баримт бичгийн бүтцийг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, журамд дараах байдлаар тусгасан байна.

- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6.3, 6.4.3-т заасан төсөл дараах ерөнхий бүтэц, агуулгатай байна.¹³

- үндэсний хөтөлбөр болон дэд хөтөлбөр¹⁴

1-р бүлэг буюу “Ерөнхий мэдээлэл”: “Ач санах”, “Өрхийн тариалалт дэмжих”, “Жаргалант сумын “Боловсрол”, “Малын хулгайтай тэмцэх” богино хугацааны хөтөлбөр, “Хог хаягдлын менежментийг сайжруулах” дэд хөтөлбөрийн төслийг тулгамдаж байгаа асуудал, нөхцөл байдлын дүн шинжилгээний гол үр дүн, төслийг боловсруулах үндэслэл шаардлагыг тодорхойлоогүй, төслийн хамрах хүрээг тодорхой тусгаагүй, хэт ерөнхий агуулгатай боловсруулагдсан байна.

2-р бүлэг буюу “Бодлогын зорилго, зорилт”: “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх”, “Эмч” “Багш” хөтөлбөрүүд бодлогын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх хугацааг тодорхойлсон боловч хөтөлбөрийг хэрэгжүүлснээр нийгэм эдийн засгийн хөгжилд гарах үр дүн, өөрчлөлтийг бодитой тусгаагүй байна.

3-р бүлэг буюу “Бодлогын хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагаа”: Батлагдсан нийт дэд хөтөлбөрийн төсөлд бодлогыг хэрэгжүүлэх үе шат бүрд зорилт тус бүрээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлсон байна.

4-р бүлэг буюу “Бодлогын үр нөлөө, бүтээгдэхүүн, шалгуур үзүүлэлт”: “Жаргалант сумын “Боловсрол”, “Малын хулгайтай тэмцэх” богино хугацааны хөтөлбөр, “Хог хаягдлын менежментийг сайжруулах” дэд хөтөлбөрийн зорилт бүрийн хүрээнд эдийн засаг, нийгмийн хөгжил, байгаль орчинд үзүүлэх нөлөөг тодорхойлж тухайн үр нөлөө бүрт шалгуур үзүүлэлтийг тодорхойлоогүй байна.

5-р бүлэг буюу “Бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэр”: Батлагдсан бүх дэд хөтөлбөрийн төсөлд тусгагдсан зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн хэмжээ, санхүүгийн эх үүсвэрийг бодлогын зорилт тус бүрээр тусгасан боловч “Эрдэнэтчүүд Эрдэнэтчүүддээ хайртай” “Чөлөөт цагийн талбай” аймгийн дэд хөтөлбөр, “Малын хулгайтай тэмцэх” Жаргалант сумын богино хэмжээний дэд хөтөлбөрт шаардлагатай хөрөнгө төсвийг тусгаагүй байна.

Б.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийн ерөнхий бүтэц агуулга, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах талаар хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, журманд дараах байдлаар тусгасан байна.

- Нэгдүгээр бүлэг. Ерөнхий мэдээлэл¹⁵
- Хоёрдугаар бүлэг. Эдийн засгийн хөгжлийн бодлогын зорилго, тэргүүлэх зорилтууд¹⁶
- Гуравдугаар бүлэг. Нийгмийн хөгжлийн бодлогын зорилго, тэргүүлэх зорилтууд¹⁷
- Дөрөвдүгээр бүлэг. Байгаль орчны бодлогын зорилго, тэргүүлэх зорилтууд¹⁸
- Тавдугаар бүлэг. Засаглалын бодлогын зорилго, тэргүүлэх зорилтууд¹⁹
- Зургаадугаар бүлэг. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ²⁰
- Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг энэхүү журмын 8 дугаар хавсралтад заасан хүснэгтийн дагуу боловсруулна.²¹

¹³ Журмын 11 дүгээр зүйлийн 52 дахь заалт

¹⁴ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3 дахь заалт

¹⁵ Журмын 11 дүгээр зүйлийн 61.1 дэх заалт

¹⁶ Журмын 11 дүгээр зүйлийн 61.2 дэх заалт

¹⁷ Журмын 11 дүгээр зүйлийн 61.3 дэх заалт

¹⁸ Журмын 11 дүгээр зүйлийн 61.4 дэх заалт

¹⁹ Журмын 11 дүгээр зүйлийн 61.5 дэх заалт

²⁰ Журмын 11 дүгээр зүйлийн 61.6 дахь заалт

²¹ Журмын 11 дүгээр бүлэг 62 дэх заалт

Аймаг орон нутгийн онцлог, эдийн засгийн нөхцөл байдал, тулгамдаж байгаа асуудал, нөхцөл байдлыг үнэлсний үндсэн дээр Монгол улсын засгийн газрын үзэл баримтлал, ойрын болон хэтийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулсан байна.

Орхон аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг үндсэн 9 бүлэг 116 зорилт, 298 багц ажил хэрэгжүүлэхээр боловсруулсан байна. Баян-өндөр сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр нь 9 бүлэгтэй 110 зорилт 195 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төслийг, Жаргалант сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг нь 9 бүлэгтэй 35 зорилт 126 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төслийг тус тус боловсруулсан байна.

1.5. Аймаг, сумын Засаг дарга нар дэд хөтөлбөрийн жагсаалтыг боловсруулж ИТХ-р батлуулаагүй байна.

Хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөлд зөвшөөрөл авах явцыг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, журамд дараах байдлаар тусгасан байна.

- Засаг дарга нь аймаг нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг, түүнийг хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийн жагсаалтын хамт боловсруулж тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.²²
- Засаг дарга нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15.2-т заасны дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг дэд хөтөлбөрийн жагсаалтын хамт боловсруулна.²³
- Дэд хөтөлбөрийн жагсаалтыг шинээр боловсруулах, үргэлжлүүлэн хэрэгжүүлэх гэж ангилан ач холбогдлоор нь эрэмбэлсэн байна.²⁴
- Шинээр боловсруулах дэд хөтөлбөрийн төслийг Засаг дарга боловсруулж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхээр Хурлын ажлын албанд 31.1-31.7-д заасан мэдээллийн хамт хүргүүлнэ.²⁵

Дэд хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар томилон ажилласан боловч нөхцөл байдлын дүн шинжилгээ, бодлогын баримт бичгийн төслийн зорилго, зорилтын уялдаа, бодлогын баримт бичгийн хувилбар бүрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийн төсөөлөл, тооцоо, олон нийтийн саналын нэгтгэл, нөлөөллийн урьдчилсан үнэлгээ, бодлогын хувилбаруудыг харьцуулан үнэлсэн тухай товч мэдээлэл, шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө зэрэг хавсралт баримт бичгүүдийг захиргааны байгууллагад хүлээлгэн өгөөгүй, өөрөөр хэлбэл журмын 1-6 дугаар хавсралтын дагуу мэдээллийг боловсруулаагүй байна.

1.6. Хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий байгууллага хууль журамд заасан үүргээ хэрэгжүүлсэн байна.

Аймаг, сумдын хэмжээнд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, нэгтгэх үүргийг аймагт ЗДТГ-ын дэргэдэх агентлаг, сумдад Засаг даргын орлогч, ЗДТГ дарга, зэрэг албан тушаалтнууд гүйцэтгэж байна.

Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх дэд хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг байгуулан төсөл боловсруулах төлөвлөгөө хийгдсэн байна.

Аймгийн ИТХ-р баталсан 8 хөтөлбөрөөс 4 хөтөлбөрийн төсөлд нөхцөл байдлын дүн шинжилгээ хийгээгүй бөгөөд бусад дэд хөтөлбөрт хийсэн нөхцөл байдлын дүн шинжилгээ нь тухайн баримт бичигт тусган шийдвэрлэх асуудал тодорхой бус, өмнө нь уг асуудлаар

²² Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь

²³ Журмын 9 дүгээр зүйлийн 44 дэх заалт

²⁴ Журмын 9 дүгээр зүйлийн 45 дахь заалт

²⁵ Журмын 9 дүгээр зүйлийн 46 дэх заалт

хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, статистик түүвэр судалгаа, олон нийтийн санал шүүмжлэлд үндэслэсэн гэх баримт нотолгоо муутай хийгдсэн байна.

Хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг тооцоо судалгаа, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тусгалгүйгээр боловсруулснаас ИТХ-ийн төлөөлөгчид уг бодлогын баримт бичигт тусгасан зорилт тус бүрээр нарийвчлан хэлэлцэлгүй баталсан нь тухайн зорилго, зорилт заагдсан хугацаанд хэрэгжихгүй байх эрсдэлд хүрч болохоор байна.

Мөн сумдууд бодлогын баримт бичгийн бодлогын хувилбарт нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийгээгүй гэж үзэж болохоор байна.

Хөгжлийн бодлогын баримт бичигт зорилго, зорилтыг тодорхойлж байгаа боловч хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг тодорхойлоогүй байна.

Дээрх нөхцөл байдлаас харахад Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, уг хуулийг сурталчилах, ялангуяа хуулийг хэрэгжүүлэх ёстой албан тушаалтнууд сайтар судалж үзэх шаардлагатай байна.

Орхон аймаг дахь
Төрийн аудитын
газар

Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль, журмын дагуу тайлагнаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн үү.

Бүлэг 2

Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль, журмын дагуу тайлагнан, хяналт-шинжилгээ, үнэлгээг хийжээ.

2.1.Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль, журамд заасан хугацаанд тайлагнасан байна.

Аймгийн Засаг даргын Үйл ажиллагааны хөтөлбөрийн 2017 онд хийгдсэн ажлын хэрэгжилтийг тооцож үзэхэд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 2017 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай биелэгдсэн арга хэмжээ 210 /бүрэн биелэсэн болон тухайн жилдээ хэрэгжилтийн хувь хангалттай арга хэмжээ/, 70 хувьтай биелэгдсэн арга хэмжээ 58, 40 хувьтай биелэгдсэн арга хэмжээ 33, 0 хувийн үнэлгээтэй буюу үнэлэх боломжгүй арга хэмжээ 3 байгаа ба жилийн дундаж үнэлгээ 86.8, 2016-2020 он хүртлэх 4 жилийн дунджаар 42.2 хувьтай хэрэгжиж байна гэж үнэлэн аймгийн ИТХ-ын 9-р хуралдаанд 2017 оны 12-р сарын 01 нд тайлагнасан байна.

Мөн аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд 9 бүлгийн 256 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөн, төлөвлөсөн арга хэмжээний 69 хувь буюу 176 арга хэмжээ нь 90-100 хувийн гүйцэтгэлтэй, 69 арга хэмжээ буюу 27 хувь нь тодорхой үр дүнд хүрсэн буюу 60-89 хувийн, 11 арга хэмжээ нь хэрэгжилт хангалтгүй буюу 31-59 хувьтай, Аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт 89,4 хувтай байна гэж үнэлэн аймгийн ИТХ-ын 9-р хуралдаанд 2017 оны 12-р сарын 01 нд тайлагнасан байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 15-р зүйлийн 15.4-д "Тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр хэлэлцэн дүгнэнэ" гэж заасны дагуу аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн 9-р хуралдаанд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн явцыг хэлэлцүүлэн, төлөвлөгөөний биелэлтийн явцыг "Хангалттай" гэж дүгнэжээ.

Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө нь нийтдээ 9 бүлэг 116 зорилттойгоос, 2018 онд 97 зорилт 83,6 хувийг шууд

хэрэгжүүлэхээр мөрийн хөтөлбөрт 18 дэд хөтөлбөр батлан хэрэгжүүлэхээр туссанаас, ирэх онд 15 хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, хоёрыг нь шинээр батлан хэрэгжүүлж эхлэхээр үндсэн чиглэлийг боловсруулж батлуулсан байна.

Баян-Өндөр сумын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд үйл ажиллагааны хөтөлбөрийн 9 бүлэг, нийт 165 арга хэмжээ тусган нийт арга хэмжээний 60,6 хувьт буюу 100 арга хэмжээ нь 90-100 гүйцэтгэлтэй, 33,3 хувь буюу 55 арга хэмжээ нь 70 хувийн гүйцэтгэлтэй 5,5 хувь буюу 9 арга хэмжээ нь 40 хувийн гүйцэтгэлтэй, 0,6 хувь буюу 1 арга хэмжээ огт хэрэгжээгүй дүнтэй байна.

2.2. Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хууль, журмын дагуу хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, хуулиар тодорхойлсон хугацаанд холбогдох байгууллагад танилцуулсан байна.

Аймгийн Засаг даргын Үйл ажиллагааны хөтөлбөрийг батлагдснаас хойш жилийн хугацаанд хийгдсэн ажлын хэрэгжилтийг тооцож үзэхэд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 2017 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай биелэгдсэн арга хэмжээ 210 /бүрэн биелэсэн болон тухайн жилдээ хэрэгжилтийн хувь хангалттай арга хэмжээ/, 70 хувьтай биелэгдсэн арга хэмжээ 58, 40 хувьтай биелэгдсэн арга хэмжээ 33, 0 хувийн үнэлгээтэй буюу үнэлэх боломжгүй арга хэмжээ 3 байгаа ба жилийн дундаж үнэлгээ 86.8, 2016-2020 он хүртлэх 4 жилийн дунджаар 42.2 хувьтай хэрэгжиж байна гэж үнэлэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн 9-р хуралдаанд танилцуулсан байна.

Аймгийн Засаг даргын Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ бодлого, зорилтын хэрэгжилтийг хүснэгтээр нэгтгэн танилцуулбал:

Бүлгийн нэр	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлийн хэрэгжилтийн хувь	Үнэлгээ өссөн дүнгээр буюу 4 жилийн гүйцэтгэлийн хувь
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ЭРҮҮЛ –АЗ ЖАРГАЛТАЙ ИРГЭД				
1.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, спортын чиглэл	17	47	94.20%	43.80%
1.2. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэл	5	13	100%	40%
ХОЁРДУГААР БҮЛЭГ. НИЙГМИЙН ДЭМЖЛЭГТЭЙ –АЗ ЖАРГАЛТАЙ ИРГЭД				
Дүн	8	18	88.30%	40%
ГУРАВДУГААР БҮЛЭГ. АЖИЛТАЙ-АЗ ЖАРГАЛТАЙ ИРГЭД				
Дүн	5	17	87.60%	40%
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ОЮУНЛАГ, ЁС ЗҮЙ, СОЁЛТОЙ-АЗ ЖАРГАЛТАЙ ИРГЭД				
Дүн	9	35	94.80%	48.50%
ТАВДУГААР БҮЛЭГ. ЭРҮҮЛ ХҮНС, ЦЭВЭР ОРЧИНТОЙ АЗ ЖАРГАЛТАЙ ИРГЭД				
5.1. Эрдэнэтийн хэрэгцээг Эрдэнэтчүүд хангана.	11	37	94.30%	40.80%
5.2. Ногоон хороолол- Миний байшин	10	20	86.50%	41.50%

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. САЙХАН ХОТЫН-АЗ ЖАРГАЛТАЙ ИРГЭД				
Дүн	13	35	70.20%	37.70%
ДОЛООДУГААР БҮЛЭГ. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ӨГӨӨЖТЭЙ-АЗ ЖАРГАЛТАЙ ИРГЭД				
Дүн	4	6	75.00%	40.00%
НАЙМДУГААР БҮЛЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТТЭЙ-АЗ ЖАРГАЛТАЙ ИРГЭД				
Дүн	9	29	69.60%	40.60%
ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. ЧАДВАРЛАГ ЗАСАГЛАЛТАЙ -АЗ ЖАРГАЛТАЙ ИРГЭД				
9.1. Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг шинэчлэх чиглэл	13	23	89.50%	45.20%
9.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангах болон бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах чиглэл	10	19	81.00%	44.70%
9.3. Батлан хамгаалах болон гамшгаас хамгаалах чиглэл	2	5	100%	40.00%
Нийт дүн	116	304	86.80%	42.20%

Хөтөлбөр, төлөвлөгөөний үнэлгээг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол болох "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д заасны дагуу бодлогын баримт бичгийн үнэлгээгээр тооцжээ.

2.3. Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг нэгтгэх, үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих, үүрэг бүхий байгууллага болон албан тушаалтан үүргээ бүрэн хэрэгжүүлэн тайлагнасан байна.

Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг аймгийн хэмжээнд нэгтгэн, тайлагнаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүргийг аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс хариуцан гүйцэтгэж байгаа бөгөөд ЗДТГ-ын даргаар хянуулан, Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн аймгийн ИТХ-аараа хэлэлцэн шийдвэрлэдэг байна.

Суманд Засаг даргын орлогч болон хөгжлийн бодлогын мэрэгжилтэнгүүд хөгжлийн бодлогын хэрэгжилтийн тайланг нэгтгэн тайлагнаж сумынхаа ИТХ-аараа хянуулан үнэлэлт дүгнэлт гаргуулж аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэст тухайн оны 12 дугаар сарын 20-ны дотор Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн тайланг хүргүүлэн ажиллаж байна.

"Эмч" дэд хөтөлбөрийн хүрээнд 2017 онд 14 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсний дагуу ажлууд хийгджээ. Үүнд:

Нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд өвчин дэгдэлтийн үед уртасгасан болон шөнийн цагийн ээлжинд ажиллагсдын зардалд 53,0 сая төгрөг, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн ажилтнуудын орон сууц барих 1 га газар, ажилтан албан хаагчдад гэр олгох, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхижуулах ажлын хүрээнд орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр сурч буй 17 эмчийг төрийн сангийн санхүүжилтээр сурган, Хавдар судлалын үндэсний төв, 3 дугаар эмнэлэг зэрэг газруудад 24 хүнийг сурган дадлагажуулахад 5,6 сая, гадны орнуудад мэргэжил дээшлүүлсэн 5 эмч, эмнэлгийн ажилтанд дэмжлэг үзүүлсэн. Ёс зүй харьцаа хандлагыг дээшлүүлэх чиглэлээр 5 удаагийн сургалт явуулж,

давхардсан тоогоор 1300 гаруй ажиллагсадыг хамруулсан. Үзлэг шинжилгээ, тусламжинд нийт 1021 албан хаагчид хамрагдсан байна.

“Чөлөөт цагийн талбай” дэд хөтөлбөрийн хүрээнд 2017 онд орон нутгийн төсөв болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Наран, Баянцагаан, Цагаанчулуут, Булаг, Бүрэнбүст, Согоот, Зэст, Дэнж, Говил, Уртбулаг багуудад шинээр амралт чөлөөт цагийн талбай байгуулах ажил хийгдэж, нийт 394,4 сая төгрөг зарцуулсан.

Мөн Оюут багийн 2-4-р байрны урд талын хүүхдийн тоглоомын талбайг сэргээн засварлах ажлыг 9,5 сая төгрөгөөр иргэдийн бүлэг тус тус хийж гүйцэтгэсэн. 5, 17, 7, 2 дугаар сургуулиудын биеийн тамирын талбайг ашиглалтанд оруулжээ.

“Ач санах” дэд хөтөлбөрийн хүрээнд 2017 онд 75,0 сая төгрөг зарцуулахаар шийдвэрлэж нийгмийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай 1-6-р түвшний ахмад настны тоон судалгааг гаргахад 1438 ахмад байна.

Ахмадын ордоны сургалтын танхимд баг бүрийн ахмадын зөвлөлийн дарга нар, ахмадын төрийн бус байгууллагуудын төлөөллийг оролцуулсан сургалт зохион байгуулав. Ахмадын зөвлөх үйлчилгээнд 4 ахмад настан хамрагдаж 10,0 сая төгрөг зарцуулжээ.

2017 онд 1000 ахмадыг “Медипас” эмнэлэгийн үзлэгт 9-р сараас эхлэн хамруулж байна. Ахмадын хороо, “Медипас” эмнэлэг хамтран “Улаан хоолой, элэгний хавдраас урьдчилан сэргийлэхэд хувь хүний оролцоо” сэдэвт сургалтыг зохион байгуулж, 100 гаруй ахмадыг хамруулж, зөвлөгөө мэдээлэл өгчээ.

Багуудад үйл ажиллагаа явуулж буй ахмадын хөгжлийн төвүүдийн үйл ажиллагааг сайжруулах эрчимжүүлэх ажлын хүрээнд Наран, Уурхайчин, Их залуу, Яргуйт багуудын ахмадын хөгжлийн төвийг тохижуулах ажил хийгдэж байна.

Хэвтрийн болон архаг өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй ахмад настанд гэрээр үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хамрах хүрээг өргөжүүлж, чанарыг сайжруулах ажлын хүрээнд “Анхдагч илгээлтийн эздийн өдөр”-ийг тохиолдуулан хэвтрийн өвчтэй 50 анхдагч настанд хүндэтгэл үзүүлэх, баг бүрийн ахмад настуудад чиглэсэн зорилтот үйл ажиллагаанд зориулан Баян-Өндөр, Жаргалант сумдын 24 баг тус бүрт 416,6 мянган төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн бөгөөд баг тус бүр ахмад настныг хамарсан нийтийн алхалт, спортын тэмцээн, олон улсын ахмадын баярын хүндэтгэлийн үйл ажиллагааг зохион байгуулсан байна.

Эрдэнэт хотын бүтээн байгуулалтанд гар бие оролцсон анхдагч нарыг оролцуулсан телевизийн цуврал нэвтрүүлэгийг ETV телевизтэй хамтран хийж үзэгчдийн хүртээл болгожээ.

Мөн ахмадуудад үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын дунд ажил мэргэжлийн туршлага солилцох үйл ажиллагаа зохион байгуулах, төрийн бус байгууллагуудыг чадавхижуулах, уялдаа холбоог сайжруулах зорилгоор уулзалт спортын тэмцээнийг зохион байгуулсан байна.

Ахмад настуудын хөдөлмөр бүтээлийг алдаршуулах төрөл бүрийн олон талт арга хэмжээнүүдийг зохион байгуулах ажлын хүрээнд “Ахмадууд дуулж байна” дуу бүжгийн цэнгүүнийг зохион байгуулж 400 гаруй ахмад настанг хамруулан дуу бүжгийн тэмцээн, урлагын тоглолтыг зохион байгуулсан байна.

Ахмад, залуу үеийн нийгэмд гүйцэтгэх үүрэг оролцооны уялдаа холбоог хөгжүүлэх зорилгоор “Шинэ хөгжлийн түлхүүр” төрийн бус байгууллагатай хамтран 9,10-р сард “Эрдэнэт-Аз жаргалтай-Үнэ цэнэтэй ахмадууд” сэдэвт хуримтлал дээр суурилсан өрхийн эдийн засгийн чадамжийг нэмэгдүүлэх 3 удаагийн сургалт зохион байгуулагджээ.

Эрдэнэтчүүд Эрдэнэтчүүдээ хайртай хөтөлбөрийн хүрээнд аймгийн Засаг даргын захирамжаар төлөвлөгөө, дэд хөтөлбөрийг удирдлагын баг, гүйцэтгэлийн баг бүрэлдэхүүнийг байгуулан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд нийт 300,0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 40,0 сая төгрөгийг хөтөлбөрийн үйл ажиллагааны зардалд зарцуулахаар Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт шилжүүлсэн. Итгэлийн зээл 260,0 сая төгрөгийг 2017 онд багтаан олгохоор ажиллаж байна.

2017 онд “Өрхийн тариалалтыг дэмжих дэд хөтөлбөр”-ийг боловсруулж, 4 зорилтын хүрээнд 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулан хэрэгжилтийг ханган, өрх бүр 6-8 сарын төмс, хүнсний ногооны хэрэгцээгээ өрхийн үйлдвэрлэлээр хангах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд 1000 өрхийг хөтөлбөрт хамруулан нэг өрхийн 250 мкв талбайд тариалах 49.5 мянган төгрөгийн өртөг бүхий төмс, хүнсний ногооны үр буюу нийт 49.5 сая төгрөгийн 50 тн төмсний үр, 590 кг хүнсний ногооны үрийг олгосон ба нийт 25 га газар тариалалт хийж 160 орчим тонн төмс, 60 гаруй тонн хүнсний ногоо хураан авсан. Үүнийг зах зээлийн ханшаар тооцоход нэг өрх 220.0 мянган төгрөгийн, нийт 220.0 орчим сая төгрөгийн төмс, хүнсний ногоо хураан авчээ.

Хөтөлбөрийн хүрээнд 46.8 сая төгрөгийн үнэ бүхий 17 ширхэг хүлэмжийг хүлэмжийн аж ахуй эрхлэх сонирхолтой өрхүүдэд 50 хувийн хөнгөлөлттэй олгох ажлыг зохион байгуулан, хүлэмжийн талбай 1560 м²-аар нэмэгдэх боломж бүрдүүлжээ.

Багийн хөгжлийг дэмжих аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 4 сарын 28-ны өдрийн хуралдаанд хэлэлцүүлэн батлуулсан бөгөөд уг хөтөлбөрийн хүрээнд: Баян-Өндөр сумын Шанд, Даваат, Дэнж баг, Жаргалант сумын Жаргалант, Улаантолгой багуудын ажлын байруудад нийт 96.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар урсгал засвар хийж ажиллах нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авч Оюут, Зэст, Булаг багууд өөрсдийн нөөц бололцоогоор байрны гадна тал, явган хүний зам, хашаа хайс, сүүдрэвч, бие засах газар, хогийн сав, цэцгийн мандал хийх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн ба Говил, Булаг, Баянбулаг, Оюут, Уртбулаг, Уурхайчин, Жаргалант, Улаантолгой багуудад компьютер, тоног төхөөрөмж, ширээ, сандал, номын шүүгээ, сейф зэрэг асуудлыг шийдвэрлэхэд орон нутгийн хөгжлийн сангаас 28.9 сая төгрөг зарцуулжээ.

Багийн үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлж, багт ажиллагсдын мэдлэг, чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор ажлын байран дахь сургалтуудыг 10-15 удаа зохион байгуулж багийн Засаг дарга, зохион байгуулагч, нийгмийн ажилтан, хэсгийн ахлагчдыг хамруулсан ба ажлын туршлага судлах, багийн ажилтнуудыг чадавхижуулах зорилгоор 9 сард Баян-Өндөр, Жаргалант сумын ЗДТГ-ын дарга, 24 багийн Засаг дарга нарыг Удирдлагын академийн сургалтанд хамруулах, Улаанбаатар хотын хороод, Дархан-Уул аймгийн багуудын ажилтай, зохион байгуулагчдыг Булган аймгийн 6 багийн үйл ажиллагаатай, нийгмийн ажилтануудыг Дархан сум, Сайншанд, Улаанбаатар хотын зарим хороодын ажилтай газар дээр нь очиж танилцах ажлыг зохион байгуулсан байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан “Багийн хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд багуудын ажлын байрны нөхцлийг сайжруулах, эд хогшил, техник хэрэгслээр хангах, багт ажиллагсдыг чадваржуулах, мэргэшүүлэх чиглэлээр богино хугацааны болон давтан сургалтанд хамруулж мэргэшлийг нь дээшлүүлэх зэрэг арга хэмжээнд орон нутгийн төсөвт 84.2 сая төгрөг тусган хэрэгжүүлэн ажиллажээ.

Орхон аймаг дахь
Төрийн аудитын
газар

Хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд
мэдээлэх, арга зүйн нэгдсэн удирдамжаар хангах ажлыг
хууль, журмын дагуу зохион байгуулсан уу.

Олон нийтэд мэдээлэх, сурталчилах ажлыг орон нутгийн захиргааны
байгууллагууд зохион байгуулсан байна.

Бүлэг 3

3.1. Хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, сурталчилах ажлыг зохион байгуулсан байна.

Хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх сурталчилах ажлыг зохион байгуулах үүргийн талаар Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд дараах байдлаар заасан байна. Үүнд:

- Батлагдсан хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, хэвлэх, сурталчилах ажлыг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон нутгийн захиргааны байгууллага хариуцан зохион байгуулна”²⁶

Аймаг, сумдын болон дэд хөтөлбөрүүдийг олон нийтэд мэдээлсэн байдлыг авч үзвэл:

- Аймгийн 2017 оны ажлын танилцуулга сэтгүүлд 10000 ш товхимол хэвлэж иргэдэд тарааснаас гадна сумд болон багийн иргэдтэй уулзалт хийх зэргээр сурталчилсан байна.
- Эрдэнэт таймс сэтгүүл 1000 ширхэг, иргэн танаа сонин 52000 ширхэг /2017.01.27/, /2017.04.10/, /2017.05.18/ дугааруудад аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр түүний биелэлтийг сурталчилж ажилласан байна.
- Аймгийн ЗДТГ-ын мэдээллийн төв нь 2017 онд 18 дэд хөтөлбөрийг сурталчилах зорилгоор орон нутгийн хэвлэл мэдээллэлийн 16 байгууллагатай хамтран ажиллаж Эрдэнэтчүүд, Эрдэнэтчүүдтэй хайртай, Ач санах, Эмч, Багш, Багийн хөгжлийг дэмжих, Чөлөөт цагийн талбай, Өрхийн тариалалтыг дэмжих дэд хөтөлбөрийн хүрээнд 70 гаруй нэвтрүүлэг, сурвалжлага, мэдээлэл бэлтгэсэн ба “хөгжил бүтээх-18”, “Багш”, “Эмч” дэд хөтөлбөрийн талаарх нэвтрүүлгийг ТВ5 болон орон нутгийн 6 телевизээр нэвтрүүлэн сурталчилжээ.

Аймгийн хэмжээний бүх сумд хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг цахим хаягаар олон нийтэд мэдээлэн ажилласан боловч үр дүнг тооцоогүй байна.

3.2. Орон нутгийн ИТХ, Засаг дарга, түүний харъяа агентлаг, байгууллага, ЗДТГ нь бодлогын бичиг баримтуудыг олон нийтэд мэдээлэх сурталчилах үүргээ хэрэгжүүлэн ажиллажээ.

Аймаг, сумдын батлагдсан дэд хөтөлбөрүүдийг олон нийтэд мэдээлэх, сурталчилах ажлыг аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор Засаг дарга түүний харъяа агентлаг байгууллага, холбогдох албан тушаалтанд хариуцуулжээ.

Аудитын явцад аймаг, сумдын батлагдсан дэд хөтөлбөрүүдийг олон нийтэд хэрхэн мэдээлсэн, сурталчилсан талаар хариуцсан албан тушаалтнуудаас асуулга авч ярилцлага хийхэд улирал тутам ард иргэдэд сонин хэвлэл, гарын авлага тараах, ард иргэдтэй уулзалт, ярилцлага зохион байгуулах хэлбэрээр мэдээлж байгаа гэсэн тайлбар өгсөн болно.

Орхон аймгийн ЗДТГ-ын мэдээлэлийн төв нь ETV телевизээр “Эмч” дэд хөтөлбөрөөр 5 удаа, “Ач санах” дэд хөтөлбөрөөр 6 удаа нэвтрүүлэг, TV10 телевизээр “Багш”, “Чөлөөт цагийн талбай”, “Эрдэнэтчүүд, Эрдэнэтчүүдтэй хайртай” дэд хөтөлбөрүүдийн хүрээнд 12 мэдээ, нэвтрүүлэг, Тусгал-1 телевизээр “Өрхийн тариалалтыг дэмжих” дэд хөтөлбөрийн хүрээнд 4 нэвтрүүлэг, “Багийн хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрийн хүрээнд 2 нэвтрүүлэг, “Эмч”, “Багш” дэд хөтөлбөрийн хүрээнд 2 нэвтрүүлэг тус тус бэлтгэн хүргэсэн байна.

²⁶ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 22 дүгээр зүйлийн 22.1 дэх заалт

Орхон аймаг дахь
Төрийн аудитын
газар

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилт

Дүгнэлт, зөвлөмж

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна.

Хөгжлийн бодлогын баримт бичгийг болосоруулахдаа хууль журмын зохих шаардлагыг бүрэн гаргаж төлөвлөөгүй боловч бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль, журмын дагуу тайлагнан, хяналт, шинжилгээ үнэлгээг хийж олон нийтэд мэдээлэх, сурталчилах ажлыг орон нутгийн захиргааны байгууллагууд зохион байгуулсан байна гэсэн ерөнхий дүгнэлт өгч байна.

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг доорх албан тушаалтнуудад зөвлөж байна.

Аймгийн Засаг даргад:

1. Шинээр батлагдах аймаг хөгжүүлэх хэтийн зорилт, дэд хөтөлбөрүүдийг хууль, журамд нийцүүлэн төлөвлөлтийн үе шатны ажлуудыг хийж хэвшүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих.
2. ЗДТГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх дэд хөтөлбөрүүдийн жагсаалт, хугацаа зэргийг тодорхой тусгаж, хэрэгжүүлэх.
3. Хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах, хяналт тавих үе шатны баримтуудыг эмхэлж, цэгцлэн архивын нэгж болгон хадгалж байх.

Сумын Засаг дарга нарт:

1. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан дэд хөтөлбөрүүдийг боловсруулах ажлыг зохион байгуулах, үйл ажиллагаанд нь хяналт тавих.
2. ЗДТГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдэх дэд хөтөлбөрүүдийн жагсаалт, хугацаа зэргийг тодорхой тусгаж, хэрэгжүүлж байх.
3. Сумдад хэрэгжиж буй хөгжлийн бодлогуудыг олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажлыг үр дүнтэй зохион байгуулах.
4. Хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах, хяналт тавих үе шатны баримтуудыг эмхэлж, цэгцлэн архивын нэгж болгон хадгалж байхыг тус тус зөвлөж байна.

МЭДЭГДЭЛ:

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 10 дугаар сарын 01-ний дотор ирүүлэхийг мэдэгдье.

ОРА-2017/НА-05

ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ТУХАЙ
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

ТАНИЛЦСАН:

Ц.НАРМАНДАХ

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ЭРДЭНЭ

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР

О.ДАШЖАМЦ

АУДИТОР

Д.ЦОГБАДРАХ

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ ТАЙЛБАР .

Төрийн Аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1-т заасны дагуу аудитын тайлангийн төслийг аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга болон Баян-Өндөр, Жаргалант сумын Засаг дарга, ажил хариуцсан холбогдох хүмүүст танилцуулж санал тайлбарыг авлаа.





ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ.


**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2017 оны 12 сарын 21 өдөр Дугаар 28 Эрдэнэт хот

Г Тайлан баталгаажуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалт, 19-р зүйлийн 19.3.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/188 дугаар тушаал, "Нийцлийн аудитын түр журам"-ын 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилт" нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг дарга, Баян-Өндөр сумын Засаг дарга болон Жаргалант сумын Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг арилгуулах, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч үр дүнг 2018 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга /Д.Батлут/, Баян-Өндөр сумын Засаг дарга /С.Ганцогт/, Жаргалант сумын Засаг дарга /Б.Зоригтбаяр/ нарт зөвлөсүгэй.
4. Аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2018 оны 4 дүгээр улиралд гарган танилцуулахыг аудитын менежер /Б.Эрдэнэ/, аудитор /Д.Цогбадрах/ нарт даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРМАНДАХ

0700559

